МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2026 оны 08 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ

ЭДИЙН ЗАСАГ 2025 ОНД

ДНБ-ий өсөлт
(2025 он)

6.8 хувь

Гадаад валютын нөөц
(2025 он)

7,005 сая $

Инфляц
(2025 оны 12 дугаар сар)

7.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл
(2025 оны 12 дугаар сар)

-1.2 их наяд ₮

Экспорт
(2025 он)

15.7 тэрбум $

Импорт
(2025 он)

11.3 тэрбум $

ГШХО
(2025 он)

3.8 тэрбум $

Зээлийн хүү
(2025 оны 12 дугаар сар)

17.2 хувь

Ажиллагчдын тоо
(2025 он)

1.36 сая

**IV улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 62.3 хувь байна.*

Бодит цалин
(2024 оны 4 дүгээр улирал)

2.4 сая

**ХҮИ 2023=100*

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ
(2025 оны 4 дүгээр улирал)

116.8 мянга

**Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.*

Өрхийн бодит орлогын өсөлт
(2025 оны 4 дүгээр улирал)

5.0 хувь

ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2026.08

ДНБ-ий өсөлт
(2026 оны 7 дугаар сар)

7.6 хувь

Гадаад валютын нөөц
(2026 оны 8 дугаар сар)

8,373 сая $

Инфляц
(2026 оны 8 дугаар сар)

12.5 хувь

Төсвийн тэнц. тэнцэл
(2026 оны 8 дугаар сар)

-2.2 их наяд ₮

Экспорт
(2026 оны 8 дугаар сар)

14.4 тэрбум $

Импорт
(2026 оны 8 дугаар сар)

8.4 тэрбум $

ГШХО
(2026 оны 2 дугаар улирал)

1.5 тэрбум $

Зээлийн хүү
(2026 оны 8 дугаар сар)

17.6 хувь

Ажиллагчдын тоо
(2026 оны 2 дугаар улирал)

1.37 сая

**II улирлын байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин 61.5 хувь байна.*

Бодит цалин
(2026 оны 8 дугаар сар)

2.6 сая

**ХҮИ 2023=100*

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ
(2026 оны 2 дугаар улирал)

119.1 мянга

**Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.*

Өрхийн бодит орлогын өсөлт
(2026 оны 2 дугаар улирал)

-4.9 хувь


1.1 ДНБ: Нийлүүлэлт

2026.II улирал

Эдийн засгийн өсөлт 2026 оны хагас жилийн байдлаар 7.7 хувьд хүрлээ. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн эрчим өндөр хэвээр байсан нь нийт өсөлтийг голлон тэтгэв. Түүнчлэн хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтвортой байж нийт өсөлтийг дэмжиж байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2026 оны эхний хагаст **7.7 хувиар өслөө.**
- Анхдагч салбар: Хөдөө аж ахуй 11.3 хувиар тэлж, өсөлтийн 1.4 нэгж хувийг, уул уурхай 29.2 хувиар тэлж, өсөлтийн 3.9 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар /боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 4.1 хувиар өсөж өсөлтийн 0.5 нэгж хувийг бүрдүүлэв.
- Үйлчилгээний салбар /худалдаанаас бусад үйлчилгээний салбарууд өссөн/ 3.8 хувиар өсөж, өсөлтийн 1.8 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 0.3 хувиар өсөж, өсөлтийг 0.05 нэгж хувиар дэмжив.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(салбараар)


ДНБ	2025.II	2026.II
	5.6	7.7
Хөдөө аж ахуй	35.6	11.3
Уул уурхай	1.1	31.5
Боловсруулах	5.8	1.2
Цахилгаан, ус	8.4	7.4
Барилга	25.2	7.9
Худалдаа	-5.7	-0.2
Тээвэр	-12.5	21.5
Мэдээлэл, холбоо	16.6	6.1
Үйлчилгээний бусад	4.5	2.6
Цэвэр татвар	0.9	0.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг голлон уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын өсөлт, хөдөө аж ахуйн салбарын өсөлт дэмжсэн бол худалдааны салбар агшиж өсөлтийг сааруулласа.
- Боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж, мэдээлэл, холбооны салбарын үйлдвэрлэл нэмэгдэж өсөлтөд эергээр нөлөөллөө.
- Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурсны нөлөөгөөр худалдааны салбар агшилттай байна.

УУЛ УУРХАЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Уул уурхайн салбар 2026 оны эхний хагаст 31.5 хувиар өслөө.
- Үүнд нүүрс олборлолт 61 сая тонн болж, өмнөх оноос 48.7 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 1.2 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин алт олборлолт 4.5 тонн болж өмнөх оны түвшинд байгаа бол газрын тосны олборлолт 1.8 сая баррель болж 7.3 хувиар буурав.

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хөдөө аж ахуйн салбар 2026 оны эхний хагаст 11.3 хувиар өслөө.
- Хаврын саруудад зарим нутгаар цас, шороон шуургатай хүйтэн байснаар бойжсон төлийн тоо толгой 18.9 сая болж (төл бойжилт 98.8 хувь) өмнөх оны мөн үеэс 1.8 сая толгойгоор буурсан байна. Түүнчлэн өмнө нь буртгэгдэж байгаагүй хэв шинжийн шүлхий өвчин тархаж, малын халдварт өвчний тархалт нэмэгдсэн нөлөөгөөр том малын зүй бус хорогдол 348 мянган толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 160 мянгаар өссөн байна.

Өсөлтийг эрэлт талаас цэвэр экспорт, төрийн хэрэглээ голлон дэмжлээ.

ДНБ-ий өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Эдийн засгийн өсөлтийг гадаад эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 13.0 нэгж хувийг цэвэр экспорт, 1.3 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин нийт хөрөнгийн хуримтлалын бууралт өсөлтийг 6.5 нэгж хувиар бууруулсан байна.


Төрийн болон өрхийн хэрэглээний өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар, өрхийн хэрэглээ 0.5 хувиар тус тус өслөө.


Хөрөнгийн хуримтлалын өсөлт *(жилийн өсөлтийн хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үндсэн хөрөнгийн хуримтлал 11.0 хувиар буурахад машин тоног төхөөрөмжийн хуримтлал өмнөх оноос 12.7 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Экспорт, импортын өсөлт
(жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 44.1 хувиар өсөж, өсөлтийн эрчим огцом нэмэгдсэнээр цэвэр экспортод эерэг нөлөө үзүүлж байна.

1.3 АЖ ҮЙЛДВЭР

2026.08 сар


Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сард 56.3 хувиар өсөв. Уул уурхайн салбарт нүүрс, зэс, олборлолтын биет хэмжээ өндөр хэвээр байгаа нь голлон нөлөөллөө.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ
(тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

НҮҮРС ОЛБОРЛОЛТ
(сая тонн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ
(голлох бүтээгдэхүүнээр)

		өмнөх оноос өөрчлөлт:
Зэсийн баяжмал	**1,604** *мян.тонн*	19.3%
Газрын тос	**2,356** *мян. баррель*	-6.2%
Алт	**6.7** *тонн*	-7.2%
Төмрийн хүдэр	**5.6** *сая.тонн*	2.2%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС *(2024=100)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сард 49.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 56.3 хувиар өслөө.
- Нүүрс, металлын хүдэр олборлолт өссөнөөр салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 68.2 хувиар өслөө.
- Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөнөөр хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, химийн бодис болон химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нөлөөгөөр **боловсруулах салбар** (нэрлэсэн дүнгээр) 15 хувь өслөө.

- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 80 орчим хувийг* уул уурхайн салбар, түүний дотор 40 орчим хувийг нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2026 оны 8 дугаар сард 83.0 сая тонн болж, өмнөх оноос 47.0 хувиар өслөө.

*2025 оны байдлаар

- 2026 оны 8 дугаар сард зэсийн баяжмалын үйлдвэрлэл 19.3 хувиар өсөж 1.6 сая тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр 5.6 сая тонн, төмрийн хүдрийн баяжмал 2.9 сая тоннд хүрч 7.6 хувиар өссөн байна.
- Алт олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс 7.2 хувиар буурч 6.7 мянган тонн болов.
- Харин газрын тос олборлолт 8 хувиар буурлаа.

- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2026 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 26.4 хувиар өссөн байна.

Үнэ өссөн:


- Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 52.5 хувиар;
- Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 56.6 хувиар;
- Газрын тос, байгалийн хий олборлолт 41 хувиар;
- Чулуун, хүрэн нүүрс олборлолт 33.1 хувиар;
- Металлын хүдэр олборлолт 29.6 хувиар;

1.4 БОЛОВСРУУЛАХ САЛБАР

2026.08 сар

Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сард бодит дүнгээр 1.4 хувиар буурав. Үүнд мах боловсруулах үйлдвэрлэл, гурилын үйлдвэрлэл, ундааны үйлдвэрлэл болон кокс болон газрын түүхий тосны боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл буурсан нь голлон нөлөөлсөн байна.


МАХ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Боловсруулсан малын мах 2026 оны 8 дугаар сард 14.3 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 45 хувиар буурлаа.
- Боловсруулсан махны биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оноос 24.1 хувиар буурлаа.


ГУРИЛ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 104.4 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өссөн байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн ч боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг гурил болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний үйлдвэрлэл бодит дүнгээр (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буураад байна.


УНДАА
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 367.5 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар буурлаа.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ буурснаар боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар буурсан байна.

САМНАСАН НООЛУУР
(тонн)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2026 оны 8 дугаар сард 1,988 тонн болж, өмнөх оны мөн үеэс 9.4 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөнөөр боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх бодит үйлдвэрлэл (2024 оны суурьтай үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан дүн) өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөн байна.

1.5 БОЛОВСРУУЛАХ САЛБАР – Барилгын салбарын орцын үйлдвэрлэл 2026.08 сар

Барилгын салбарын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент, вакум цонх болон хаалга, металл бэлдэц болон цувимлын үйлдвэрлэл нэмэгдсэн бол катодын зэсийн үйлдвэрлэл буурсан байна.


ЦЕМЕНТ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 1,447 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар өсөөд байна.


КАТОДЫН ЗЭС
(тонн)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, УСХ

- Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 4,273 тонн болж, өмнөх оны мөн үеэс 17 хувиар буураад байна.


МЕТАЛЛ БЭЛДЭЦ, ЦУВИМАЛ
(мян. тонн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Металл бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 44.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өсөөд байна.

ВАКУМ ЦОНХ, ХААЛГА
(мян. м.кв)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 27.7 мянган м.кв болж, өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өслөө.


1.6 ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР

2026.II-р улирал - 08 сар

Үйлчилгээний салбарыг тээвэр, зочид буудал, нийтийн хоолны салбарууд дэмжсэн бол өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан худалдааны салбар өсөлтийг сааруулж байна.

ХУДАЛДАА

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)




Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, УСХ

ЗОЧИД БУУДАЛ, ХООЛ

(салбарын орлого, тэрбум төгрөг, ХҮИ-ээр засварласан бодит дүн)



Тэмдэглэл: Тус салбаруудын статистик нь 45 хоногийн хоцрогдолтой зарлагддаг.

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, УСХ

ТЭЭВЭР

(тээсэн ачаа, сая тонн)

	2025.08	2026.08	өмнөх оноос:
Төмөр зам	29.5	41.2	39.7%
Уул уурхайн бүт.	21.1	31.2	47.9%
Агаар	6.28	6.56	4.4%

	2025.I	2026.I	
Авто зам*	18.4	28.6	55.1%
Уул уурхайн бүт.	12.2	18.7	52.5%


**мянган тонн*

Тэмдэглэл: Авто замын тээврийн статистик улирлаар зарлагддаг.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

(жуулчдын тоо, мянган хүн)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2026 оны 7 дугаар сард нэрлэсэн дүнгээр 40.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өссөн бол үнийн нөлөөг засварласан бодит дүнгээр 0.3 хувиар агшсан байна.

- 2026 оны 7 дугаар сард нэрлэсэн дүнгээр зочид буудлын салбарын борлуулалтын орлого 15.2 хувиар өсөж, нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 9.9 хувиар өссөн байна.
- Үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлого 6.0 хувиар өсөж, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 1.5 хувиар өссөн байна.

- Төмөр замаар 2026 оны 8 дугаар сарын байдлаар 41.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.7 хувийн өсөлттэй байна.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 4.4 хувийн өсөлттэй байна.
- Авто замаар* 2026 оны 2 дугаар улиралд 62.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 53.3 хувийн өсөлттэй байна.

**Тайлбар: Авто тээврийн статистик улирал тутам зарлагддаг болно.*


- 2026 оны эхний найман сарын байдлаар Монгол Улсад ирсэн жуулчдын тоо 734.5 мянгад хүрлээ. Энэ нь зөвхөн наймдугаар сарын байдлаар өмнөх жилүүдийн бүтэн жилийн жуулчдын тоотой дүйцэх хэмжээ юм.

2.1 ГАДААД ХУДАЛДАА

2026.08 сар

2026 оны 8 дугаар сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 22.9 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 8 дугаар сард 14,400 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 57 хувиар өслөө.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүллээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ *(сая ам.доллар)*



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 5,435 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 56 хувиар өслөө.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 6,291 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 83 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 806 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46 хувиар өслөө.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 423 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 хувиар өслөө.


ИМПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2026 оны 8 дугаар сард импорт 8,406 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна.
- Нийт импортын 21 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 19 хувийг тоног төхөөрөмж, 13 хувийг барилгын материал, 10 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 8 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Шатахууныг импорт 41 хувиар, барилгын материал 16 хувиар, тоног төхөөрөмж 9 хувиар, хүнс 7 хувиар тус тус өссөн нь импортыг нэмэгдүүллээ.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТ *(сая ам.доллар)*



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 1,752 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 41 хувиар өссөн байна.
- Тоног төхөөрөмжийн импорт 1,599 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өссөн байна.
- Суудлын автомашины импорт 679 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар буурлаа.
- Барилгын материалын импорт 1,121 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16 хувиар өссөн байна.
- Хүнсний импорт 835 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өслөө.

2.2 УУЛ УУРХАЙН ЭКСПОРТ

2026.08 сар

2026 оны 8 дугаар сард уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүллээ.


НҮҮРС
(сая тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 77.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 47 хувиар өслөө.


ЗЭСИЙН БАЯЖМАЛ
(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 1,768 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 22 хувиар өслөө.


ТӨМРИЙН ХҮДЭР
(мян. тонн)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 6,014 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өслөө.

ГАЗРЫН ТОС
(мян. баррель)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Газрын тосны экспортын биет хэмжээ 2026 оны 8 дугаар сард 2,223 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурлаа.


2.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭКСПОРТ

2026.08 сар

2026 оны 8 сард хөдөө аж ахуйн экспорт өмнөх оны мөн үеэс 38 хувиар өслөө.


ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ ЭКСПОРТ

(сая ам.доллар)




ХОНЬ, ЯМААНЫ МАХ

(сая ам.доллар)




САМНАСАН НООЛУУР

(сая ам.доллар)




АРЬС, ШИР

(сая ам.доллар)



БОЛОВСРУУЛСАН МАХ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

АДУУ, ҮХРИЙН МАХ


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УГААСАН НООЛУУР


(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

НООС

(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС
($/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2026 оны 8 дугаар сарын дундаж үнэ 274 ам.доллар хүрч, өмнөх сараас 3 хувиар буурсан бол өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн байна.

ЗЭС
($/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)



Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2026 оны 8 дугаар сарын дунджаар 14429 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 44 хувиар өссөн байна.


ТӨМРИЙН БАЯЖМАЛ
($/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)



Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2026 оны 8 дугаар дундаж үнэ 98 ам.долларт хүрч, өмнөх сараас 2 хувиар, өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС
($/баррель, Брент)




Эх сурвалж: Блүүмберг

- Брент газрын тосны 2026 оны 8 дугаар сарын дундаж үнэ 101 ам.долларт хүрч өмнөх сараас 6 хувиар, өмнөх оны мөн үеэс 31 хувиар өслөө.

4. УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН АРИЛЖАА 2026.08 сар

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2026 оны 8 сард 23 сая тонн нүүрс, 4.0 сая тонн төмрийн хүдэр арилжаалаад байна.

НҮҮРСНИЙ АРИЛЖАА
(сая тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржс

- 2026 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 82.4 сая тонн нүүрс арилжиж, 8.5 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2025 онд 21.8 сая тонн нүүрс арилжиж, 1.6 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 8 сард 23 сая тонн нүүрс борлуулаа.


НҮҮРСНИЙ ДУНДАЖ ҮНЭ
(ам.доллар/тонн)



Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- 2026 оны 8 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 108 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 134 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 27 ам.доллар, дээд үнэ 171 ам.доллар хүрэв.

ТӨМРИЙН АРИЛЖАА
(мянган тонн)



Эх сурвалж Монголын хөрөнгийн биржс

- 2026 оны 8 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 13 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 859 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2025 онд 5.9 сая тонн төмрийг арилжаалж, 380 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2026 оны эхний 8 сард 4.0 сая тонн төмрийн хүдэр борлуулаа.

ТӨМРИЙН ДУНДАЖ ҮНЭ
(ам.доллар/тонн)



Эх сурвалж: Монголын хөрөнгийн биржс

- Төмрийн хүдэр болон баяжмалын 8 дугаар сарын дуудах дундаж үнэ 67 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 71 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 8 дугаар сард хэлцлийн доод үнэ 58 ам.доллар, дээд үнэ 85 ам.доллар хүрэв.


5. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ

2026.07-08 сар

Төлбөрийн тэнцэл 2026 оны 8 дугаар сарын байдлаар 826 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2026 оны 8 дугаар сард өмнөх оноос 2,689 сая ам.доллароор өсөж, 8,373 сая ам.долларт хүрлээ.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

(сая ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

- Төлбөрийн тэнцэл 2026 оны 7 дугаар сарын байдлаар 826 сая ам.долларын ашигтай байна.
- Урсгал данс 249 сая ам.долларын ашигтай байгаа бол, санхүүгийн данс 834 сая ам.долларын ашигтай гарлаа.

Тэмдэглэл: Төлбөрийн тэнцлийн статистик 1 сарын хоцрогдолтой зарлагддаг.

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ

(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Гадаад валютын улсын нөөц 2026 оны 8 дугаар сарын эцэст 8,373 сая ам.доллар болж, өмнөх сараас 410 сая ам.доллароор, өмнөх оны мөн үеэс 2,689 сая ам.доллароор тус тус өслөө.

ХАНШИЙН ӨДРИЙН ӨӨРЧЛӨЛТ

(төгрөг/ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 8 дугаар сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларч сарын эцэст 3,595 төгрөгт хүрлээ.

ГАДААД ВАЛЮТЫН ДУУДЛАГА ХУДАЛДАА

(сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

- Төв банк 2026 оны 8 дугаар сард 249 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Төв банк 2026 оны эхний 8 сарын байдлаар мөн үеэс 1,213 сая ам.доллароор бага буюу нийт 2,618 сая ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


6.1 ИНФЛЯЦ

2026.08 сар

Инфляц 2026 оны 8 дугаар сард 12.5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 3.7 нэгж хувиар өслөө. Инфляц өмнөх оны мөн үеэс өсөхөд мах, шатахуун болон боловсролын үйлчилгээний үнэ голлон нөлөөллөө. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 1.1 хувиар өссөн байна.

ЖИЛИЙН ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Инфляц 2026 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 12.5 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 3.6 нэгж хувь (29.3 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 8.8 нэгж хувь буюу 70.7 хувийг эзэлж байна.

САРЫН ИНФЛЯЦ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- 2026 оны 8 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.1 хувиар өслөө.
- Сарын инфляц 1.1 хувь гарахад улсын их дээд сургуулийн төлбөр, хувийн бага сургуулийн төлбөр өмнөх сараас 16.5, 22.5 хувиар өссөн нь нөлөөлөв.

СУУРЬ ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2026 оны 8 дугаар сард суурь инфляц 7.7 хувь гарч, нийт инфляцын 4.7 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 6 сар дараалан өссөн үзүүлэлттэй байна.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИНФЛЯЦ *(хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Мах, шатахуун, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт эрчимжсэнээр жилийн инфляцын 50.5 хувийг бүрдүүллээ.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 57.9 хувиар өслөө.
- Шатахууны үнэ өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар өслөө.


6.2 ИНФЛЯЦ

2026.08 сар

Олон улсад чингэлэг тээврийн үнэ 4,500 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өслөө. Хүнсний үнийн индекс 2026 оны 8 дугаар сард өмнөх сараас 1.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХҮНСНИЙ БА ХҮНСНИЙ БУС ИНФЛЯЦ

(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хүнсний инфляц 2026 оны 8 дугаар сард 21.5 хувь болж, нийт инфляцын 5.8 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц эрчимжихэд махны үнийн өсөлт нөлөөллөө.
- Хүнсний бус инфляц 9.1 хувьд хүрч, нийт инфляцын 6.6 нэгж хувийг бүрдүүллээ.

ИМПОРТЫН ИНФЛЯЦ БА ВАЛЮТЫН ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ

(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк

- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2026 оны 8 дугаар сард дунджаар 3,594 төгрөг болж, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2026 оны 8 дугаар сард өмнөх сараас 1.3 хувиар өслөө.

ЧИНГЭЛЭГ ТЭЭВРИЙН ҮНЭ

(1000$/40 фут контейнер)



Эх сурвалж: Drewry World Container Index

- Ойрх Дорнодын мөргөлдөөний дараа харьцангуй тогтвортой өсөлттэй байсан чингэлэг тээврийн үнэ сүүлийн саруудад огцом өслөө.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2026 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 4,500 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.4 дахин өссөн байна.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.

ХҮНСНИЙ ҮНИЙН ИНДЕКС

(хувь)



Эх сурвалж: FAO

- НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2026 оны 8 дугаар сард 133.3 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар, өмнөх сараас 1.9 хувиар тус тус өссөн байна.
- Сүүлийн сар дэлхийн зах зээл дээр ургамлын тос, элсэн чихэр, үр тариа болон махны үнэ өссөн байна.


7.1 НЭГДСЭН ТӨСӨВ

2026.08 сар

Нэгдсэн төсвийн нийт орлого 2026 оны 8 дугаар сарын байдлаар 22.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар, зарлага 22.2 их наяд тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар өслөө.

ТӨСВИЙН ОРЛОГО


(орлогын эх үүсвэрээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТАТВАРЫН ОРЛОГО


(татварын төрлүүдээр, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

ТӨСВИЙН ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

УРСГАЛ ЗАРДАЛ

(зардлын ангиллаар, их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Оны эхнээс нийт АМНАТ-ийн 65 хувийг Ирээдүйн өв санд хуваарилж эхэлсэн нь сангуудын орлогын хуримтлалыг өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өсгөсөн байна.
- Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны 8 дугаар сарын байдлаар 20.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөг буюу 11.1 хувиар өссөн байна.
- Татварын орлого 2026 оны эхний 8 сард 18.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөг буюу 11.7 хувиар өссөн байна. Үүнд, НД болон НӨАТ-ын орлогын өсөлт голлон нөлөөллөө.

- Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ өсөж, түүхий эд бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өндөр байгаатай холбоотойгоор нийт АМНАТ-ын орлого 3.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 их наяд төгрөг буюу 1.6 дахин өссөн нь төсвийн орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ.
- ААНОАТ-ын орлого өмнөх оны мөн үеэс 272.4 тэрбум төгрөгөөр (8.7 хувь) өссөнөөр ОАТ-ын орлого нэмэгдлээ, харин онцгой албан татварын орлого 86.7 тэрбум төгрөгөөр (12.4 хувь) буурсан байна.

- Нэгдсэн төсвийн зарлага 2026 оны 8 дугаар сард 22.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.9 их наяд төгрөг буюу 15.1 хувиар өссөн байна.
- Нийт өсөлтийн 9.5 нэгж хувийг урсгал зардлын өсөлт, 5.1 нэгж хувийг хөрөнгийн зардлын өсөлт бүрдүүлсэн байна.
- Хөрөнгийн зардал 4.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 их төгрөг буюу 30.7 хувиар өсөхөд барилга байгууламжийн зардлын өсөлт голлон нөлөөлсөн байна.

- Цалингийн зардал 5.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 их наяд төгрөг буюу 25.0 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 6.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 655.7 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар тус тус өссөн нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.
- Засгийн газрын урсгал шилжүүлэг 1.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 65.0 тэрбум төгрөгөөр (3.6%) өсөж, бараа үйлчилгээний бусад зардал 636.2 тэрбум төгрөгт хүрч, 7.4 тэрбум төгрөгөөр (1.1%) буурсан байна.


7.2 ТӨСВИЙН ТЭНЦЭЛ БА ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

2026.08 сар

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 8 дугаар сарын байдлаар 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 8 дугаар сарын байдлаар 2.2 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэврийг нэмэгдүүлсэн нь орлогоос давсан зарлагыг бий болгож, тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад голлох нөлөө үзүүллээ.

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

(их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

- Нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2026 оны 8 дугаар сарын байдлаар 619.1 тэрбум төгрөгийн ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс төсвийн ашиг 630.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Төсвийн үндсэн тэнцэл нь нийт зардлаас хүүгийн зардлыг хасаж тооцсон тэнцэл бөгөөд 2026 оны 8 дугаар сард 1.8 их наяд төгрөгийн ашигтай гарсан байна.
- Энэ нь хүүгийн төлбөрийг эс тооцвол төсвийн суурь үйл ажиллагаа ашигтай гарсныг илэрхийлж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(Зүүн тэнхлэг: их наяд төгрөг
Баруун тэнхлэг: ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2026 оны 2 дугаар улирлын байдлаар 36.2 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсөж, ДНБ-ий 35.5 хувьтай тэнцүү байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)

(их наяд төгрөг)


	2025.II	2026.II	Өсөлт/ бууралт
Засгийн газрын нийт өр	35.5	36.2	2.0%
ДНБ-д эзлэх хувь	*39.5%*	*35.5%*	*-4.0%*
Засгийн газрын дотоод өр	0.6	1.1	83.3%
Засгийн газрын гадаад өр	32.2	32.2	0.0%
Үнэт цаас	9.1	9.1	0.0%
Зээл	23.2	23.2	0.0%
Засгийн газрын бусад өр	2.8	3.0	7.1%
ЗГ өрийн баталгаа	0.2	0.2	0.0%
Нийслэлийн үнэт цаас	2.6	2.8	-7.7%

Эх сурвалж: Сангийн яам

- Засгийн газрын нийт өрийн 25.0 хувийг гадаад үнэт цаас, 63.9 хувийг гадаад зээл, 5.1 хувийг орон нутгийн гадаад үнэт цаас үлдсэн 5.6 хувийн засгийн газрын дотоод өр бүрдүүлж байна.
- Нийт өрийн бүтцэд гадаад өр давамгайлж байгаа нь валютын ханшийн хэлбэлзэл, олон улсын зах зээлийн нөхцөл байдал, хүүгийн түвшний өөрчлөлтөөс шууд хамаарах тул өрийн эрсдэл харьцангуй өндөр байгааг илэрхийлж байна.

Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өсөж, 54.4 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2026 оны 8 дугаар сард 48.4 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 14.3 хувьд хүрлээ.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ӨСӨЛТ *(жилийн өсөлт, хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Мөнгөний нийлүүлэлт 2026 оны 8 дугаар сарын эцэст 54.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 24.7 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 13.2 нэгж хувь, гадаад валютын харилцах 5.4 нэгж хувь, төгрөгийн харилцах 7.0 нэгж хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.2 нэгж хувиар тус тус өсгөсөн бол гадаад валютын хадгаламж 1.0 нэгж хувиар буурах нөлөө бүрдүүлсэн байна.

ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ *(жилийн өсөлт, хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Нийт хадгаламж 33.8 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 28.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.0 хувиар өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.2 хувиар буурлаа.


ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ *(хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2026 оны 8 дугаар сарын эцэст 48.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 14.3 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.3 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар өслөө.

ХҮҮГИЙН ТҮВШИН *(жигнэсэн дундаж хувь)*



Эх сурвалж: Монголбанк


- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 8 дугаар сард 17.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.5 нэгж хувиар, өмнөх сараас 0.1 нэгж хувиар тус тус өссөн байна.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2026 оны 8 дугаар сард 11.7 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.02 өмнөх сараас 0.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

8.2 НОГООН САНХҮҮЖИЛТ

2026 оны 2 дугаар улирал

Банкнуудын ногоон зээлийн нийт үлдэгдэл 2026 оны 2 дугаар улирлын байдлаар 2.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх улирлаас 13.6 хувиар нэмэгджээ. Банкнуудын нийт зээлийн үлдэгдэлд ногоон зээлийн эзлэх хувь 5.9 хувьд хүрлээ.


НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ӨСӨЛТ *(улирлын өсөлт, хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- 2026 оны II улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдэл өмнөх улирлаас 13.6 хувиар өсөж, өсөлтийн эерэг хандлага үргэлжилж байна. Хэдий 2022-2023 оны огцом өсөлттэй үеэс харьцангуй саарсан ч ногоон санхүүжилт банкны салбарт тогтвортой байр суурь эзэлж эхэлж буйг харуулж байна.


ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ХУВЬ *(хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь 1.8 хувь байгаа нь банкны системийн дундаж болох 5.0 хувиас харьцангуй бага түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн чанаргүй зээлийн хувь тогтвортой буурсан нь уг төрлийн санхүүжилтийн эрсдэл харьцангуй бага, чанарын үзүүлэлт илүү сайн байгааг харуулж байна.

НИЙТ ЗЭЭЛД НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН ЭЗЛЭХ ХУВЬ *(хувь)*



Эх сурвалж: Монголбанк

- Ногоон зээлийн үлдэгдэл нийт зээлийн 5.9 хувийг эзэлж, сүүлийн жилүүдэд тогтвортой өссөн байна. Гэсэн ч банкны салбарын нийт зээлийн багцтай харьцуулахад ногоон зээлийн хэмжээ харьцангуй бага хэвээр байгаа нь ногоон санхүүжилтийн орон зай цаашид тэлэх боломжтойг харуулж байна.

НОГООН ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ *(салбараар, хувь)*



Эх сурвалж: Монголбанк


- 2026 оны I улирлын байдлаар ногоон зээлийн үлдэгдлийн дийлэнх буюу 53.8% нь эрчим хүчний хэмнэлтийн чиглэлд төвлөрч байна. Мөн тогтвортой ХАА, газар ашиглалт, ой болон эко аялал жуулчлалын салбар 19.9 хувийг эзэлж байгаа бол сэргээгдэх эрчим хүчний салбарын эзлэх хувь 12.6% байна. Энэ нь ногоон санхүүжилт харьцангуй цөөн чиглэлд төвлөрч, бусад ногоон салбаруудын санхүүжилтийн орон зай харьцангуй бага хэвээр байгааг харуулж байна.

8.3 НОГООН САНХҮҮЖИЛТ

2026 оны 2 дугаар улирал

Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 15.0 хувь, жигнэсэн дундаж хугацаа 45.1 сар байна. Ногоон төгрөгийн зээл нь банкны зээлтэй харьцуулахад бага хүүтэй, урт хугацаатай олгогдож байгаа нь тогтвортой, урт хугацааны ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих хандлага нэмэгдэж байна.


ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХҮҮ *(жигнэсэн дундаж хувь, жилээр)*



Эх сурвалж: Монголбанк

- Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 15.0 хувь байгаа нь банкны зээлийн дундаж хүү болох 17.3 хувиас доогуур түвшинд байна. Сүүлийн жилүүдэд ногоон зээлийн хүү нийт банкны зээлийн хүүгээс харьцангуй бага хадгалагдаж байгаа нь ногоон санхүүжилтийг илүү таатай нөхцөлөөр дэмжих хандлага үргэлжилж байгааг харуулж байна.

ШИНЭЭР ОЛГОСОН ТӨГРӨГИЙН ЗЭЭЛИЙН ХУГАЦАА *(жигнэсэн дундаж хугацаа,сар)*



Эх сурвалж: Монголбанк

- Шинээр олгосон ногоон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа 45.1 сар байгаа нь банкны зээлийн дундаж хугацаа болох 39.8 сараас урт байна. Ногоон зээлүүд харьцангуй урт хугацаатай олгогдож байгаа нь эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөрөнгө оруулалт зэрэг урт хугацааны өгөөжтэй төслүүдийг санхүүжүүлэх хандлага нэмэгдэж байгааг илтгэж байна.

НОГООН БОНДУУДЫН МЭДЭЭЛЭЛ– 2026.03

НОГООН БОНД - 1
Арилжааны банк *(2023.12.15)*

17 тэрбум ₮

16% | 3 жил

НОГООН БОНД - 2
Арилжааны банк *(2024.10.17)*

25 сая $

SOFR+3.4% | 3 жил

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-1)
Хог хаягдлыг дахин боловсруулах салбар *(2024.11.06)*

11 сая $

10% | 3 жил

НОГООН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН БОНД (ТРАНЧ-2)
Хог хаягдлыг дахин боловсруулах салбар *(2025.01.03)*

4 сая $

10% | 3 жил

БАТАЛГААЖААГҮЙ НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД
Арилжааны банк *(2024.10.23)*

50 сая $

9.5% | 5 жил

НОГООН БОЛОН НИЙГМИЙН БОНД
Арилжааны банк *(2025.01.02)*


50 сая $

8% | 5 жил

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Ажиллагчдын тоо 1 сая 368 мянга болж багассан нөлөөгөөр ажиллах хүчний оролцооны түвшин 61.5 хувь болж буурлаа.

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, ХҮЙСЭЭР *(мянган хүн, хувь)*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, САЛБАРААР *(мянган хүн)*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН *(хувь)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ДУНДАЖ ЦАЛИН, ГОЛЧ ЦАЛИН, БОДИТ ЦАЛИН *(мянган төгрөг)*



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 22 мянга буюу 1.6 хувиар буурч 1 сая 368 мянгад хүрлээ.
- 2026 оны 2 дугаар улиралд эрэгтэй ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянгаар буурсан бол эмэгтэй ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 9 мянгаар өссөн дүнтэй байна.

- Ажиллагчдын тооны бууралтад нийт ажиллагчдын дөрөвний нэгийг бүрдүүлдэг хөдөө аж ахуйн салбарын ажиллагчдын тоо өмнөх оны мөн үеэс 46 мянгаар буюу 12 хувиар, боловсруулах салбарынх 24 мянгаар буюу 20 хувиар тус тус буурсан нь голчлон нөлөөлжээ.
- Харин үйлчилгээний салбар 40 мянган ажиллагчдаар нэмэгдсэний дийлэнхийг санхүү, даатгал болон боловсролын салбарын ажиллагчид бүрдүүлсэн байна.


- Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 13 мянгаар өссөнөөр ажилгүйдлийн түвшин 5.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өссөн байна.
- Харин ажиллах хүчний оролцооны түвшин ажиллагчдын тоо буурсан нөлөөгөөр өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурч 61.5 хувьд хүрээд байна.

- Дундаж цалингийн хэмжээ 2026 оны 8 дугаар сарын байдлаар 2 сая 951 мянган төгрөг байна.
- Улсын голч цалин 2 сая 518 мянган төгрөг (дундаж цалингаас 433 мянган төгрөгөөр бага) байна. Энэ нь ажилчдын талаас илүү нь 2.5 сая төгрөгөөс бага цалин авч байгааг илэрхийлж байна.
- Хэрэглээний үнийн индексээр засварлагдсан бодит цалин 2 сая 254 мянган төгрөгт хүрлээ.

(Энд ХҮИ 2023=100)

Өрхийн бодит орлого 4.9 хувиар буурлаа.

ӨРХИЙН БОДИТ ОРЛОГИЙН ӨСӨЛТ
(хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн бодит орлого 4.9 хувиар агшлаа.
- Өрхийн орлогын бууралтад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 97.6 мянган төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлөв.

Тэмдэглэл: УСХ-ноос өрхийн бодит орлогыг 2020 оны зэрэгцүүлэх үнээр тооцов.

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ӨСӨЛТ
(хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн орлогын өсөлт зарлагын өсөлт 5.8 хувьд болж удааширч, иргэдийн хадгаламжийн өсөлт алгуур эрчимжиж байна.

ӨРХИЙН БОДИТ ДУНДАЖ ОРЛОГИЙН ТАРХАЛТ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Өрхийн тооны тэнцүү 5 бүлгээр хамгийн өндөр орлоготой бүлгийн орлого нь хамгийн бага орлоготой бүлгээс:
  - бодит цалингийн орлого нь 3.4 дахин өндөр;
  - бодит өрхийн үйлдвэрлэлийн орлого нь 2.8 дахин өндөр;
  - бодит тэтгэвэр тэтгэмжийн орлого нь 1.1 дахин өндөр байна.

Тэмдэглэл: Өрхийн тооны тэнцүү 5 бүлгээс хамгийн бага орлоготой бүлгийн өрхийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, өрхийн үйлдвэрлэлийн орлогыг өрхийн бусад бүлгүүдтэй бүлгүүдтэй харьцуулан тооцов.

ӨРХИЙН НЭРЛЭСЭН ОРЛОГО
(сая төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Хот, хөдөөгийн нэрлэсэн орлогын зөрүү хадгалагдаж байна. Үүнд, 2025 оны 2 дугаар улиралд нийслэлийн өрхийн дундаж орлого хөдөөгийн өрхөөс 1.5 дахин өндөр байсан бол 2026 оны 2 дугаар улирлын байдлаар зөрүү хадгалагдаж, ижил түвшинтай байна.

Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 2 дугаар улиралд 274.2 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 мянгаар буюу 9.5 хувиар өслөө.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2026 оны 2 дугаар улиралд 274.2 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 2.8 мянгаар өслөө.
- Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-үүд өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар нэмэгдсэн бол, үйл ажиллагаа зогсоосон болон олдохгүй байгаа аж ахуйн нэгжүүд 10.8 хувиар буурсан байна.
- Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо буурсан хэдий ч идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж буй нь эдийн засгийн идэвхжилттэй байгааг харуулж байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо худалдааны салбарт 2.4 мянга, үйлчилгээний салбарт 2.5 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 10.6 хувиар өссөн байна.


ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянга, ажиллагчдын тоогоор)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Үйл ажиллагаа явуулж буй 119.1 мянган ААН-ийн 103.6 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай жижиг ААН-үүд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.8 хувиар өссөн байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС *(улирлаар, 2018=100)*



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний тев (Эн-Ар-Си-Си ХХК)


- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2026 оны 1 дүгээр улиралд 107.2 болж өмнөх оны мөн үеэс 2.8 нэгжээр өслөө.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 21.1 нэгжээр буурсан.
- Мөн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 10.5 нэгжээр өссөн бөгөөд үүнд бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлт өссөн нь нөлөөллөө.

11.1 ГАДААД ЭДИЙН ЗАСАГ - ОХУ

2026.07-08 сар

ОХУ-ын эдийн засаг 2026 оны 2 дугаар улиралд 1.3 хувиар өслөө. Инфляцын түвшин 2026 оны 8 дугаар сард 6.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.4 нэгж хувиар буурсан байна.


БОДИТ ДНБ-ИЙ ӨСӨЛТ
(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- ОХУ-ын эдийн засаг 2026 оны 2 дугаар улиралд 1.3 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар нэмэгдлээ.


ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ
(хувь, тухайн сар)



Эх сурвалж: Блүүмберг

- 2026 оны 7 дугаар сарын байдлаар экспорт 45 тэрбум ам.доллар, импорт 31.4 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 13.6 тэрбум ам.долларын ашигтай байна.
- Экспорт 2026 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өслөө.
- Импорт 2026 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 22 хувиар өслөө.


ИНФЛЯЦ
(хувь)



Эх сурвалж: Блүүмберг

- ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.
- Инфляцын түвшин 2026 оны 8 дугаар сард 6.3 хувь болж, өмнөх сараас 0.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурсан байна.
- Жилийн инфляцын түвшин 2025 онд 8.7 хувьд хүрч, өмнөх оноос 0.3 нэгж хувиар өслөө.
- ОХУ-ын төв банкнаас 4 дүгээр сарын 27-ны өдөр бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулж, 14.5 хувьд хүргэх шийдвэр гаргасан.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)
(нэгж, хувь)



Эх сурвалж: Блүүмберг


- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2026 оны 8 дугаар сард 50.7 болж, өмнөх сараас 0.4 нэгжээр өслөө.
- Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2026 оны 7 дугаар сарын байдлаар 0.4 хувь болж, өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурлаа.

11.2 ГАДААД ЭДИЙН ЗАСАГ - БНХАУ

2026.08 сар

Дотоод эрэлт сул хэвээр байгаа ч нийлүүлэлтийн тогтвортой өсөлтийг хадгалж, экспорт нэмэгдсэнээр БНХАУ-ын эдийн засаг 2026 оны эхний хагас жилд 4.7 хувиар өссөн байна.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ *(хувь)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 2 дугаар улиралд 4.3 хувиар өсөж, эхний хагас жилийн өсөлт 4.7 хувьд хүрсэн байна.
- 2026 оны 7 дугаар сард экспорт 25.0 хувиар, импорт 28.2 хувиар тус тус өсөж өмнөх сараас өссөн үзүүлэлттэй байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагддаг.

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖИЖИГЛЭН ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ *(хувь)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн гарц 2026 оны 8 дугаар сард 5.2 хувиар өссөн нь өмнөх сарын өсөлтөөс 0.7 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны борлуулалт 8 дугаар сард 0.4 хувь болж саарсан байна.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагддаг.


ИНФЛЯЦ *(хувь)*



Эх сурвалж: Блүүмберг

- Хэрэглээний үнийн индекс 2026 оны оны 8 дугаар сард 0.8 хувьд хүрч өнгөрсөн сартай харьцуулахад 0.3 нэгж хувиар өссөн байна.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2026 оны 8 дугаар сард 3.8 хувиар өссөн нь үйлдвэрлэлийн өртгийн дарамт өндөр хэвээр боловч өмнөх сараас 0.3 нэгж хувиар өссөн нь эдийн засгийн эрэлт нэмэгдэж байгааг илэрхийлж байна.

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI) *(нэгж)*



Эх сурвалж: БНХАУ-ын Үндэсний статистикийн хороо

- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2026 оны 8 дугаар сард 49.8 болж, аж үйлдвэрийн үйл ажиллагаа агшилтын бүсэд шилжсэнийг илэрхийлж байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд мөн 49 түвшинд байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий эдийн нөөц зэрэг үзүүлэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ